



СУРГУУЛИЙН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА (ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Г.Бямбатогтох^а, Э.Эрдэнзул^б

^аМУБИС-Багшийн сургууль, багш;

^бМУБИС-Багшийн сургууль, оюутан;

Холбоо барих зохиогч: Byambatogtokh@msue.edu.mn

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь зургаан настай хүүхдийн зан үйлийн онцлогийг тодорхойлж, эцэг эх болон багшийн үнэлгээг харьцуулах юм. Судалгаанд Дархан хотын “Од” ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид суралцаж буй 60 сурагч хамрагдсан бөгөөд мэдээллийг цуглуулахдаа асуумж болон ажиглалтын аргыг ашиглав. Судалгааны дүнгээс харахад нийт хүүхдийн 65% нь эерэг зан үйл давамгайлсан (ээлдэг харилцах - 42%, дүрэм баримтлах - 37%, бусдад тусч байх - 31%) бол 35% нь сөрөг зан үйл давамгайлсан (анхаарал төвлөрөл сул - 22%, дүрэм зөрчих - 18%, түрэмгий хандлага - 12%, хэт хөдөлгөөнт байдал – 9%) нь тогтоогдов. Эцэг эхийн үнэлгээгээр хүүхдийн 72% нь эерэг зан үйл давамгайлдаг гэж үнэлэгдсэн бол багшийн үнэлгээгээр зөвхөн 58% нь эерэг, харин 42% нь сөрөг зан үйл давамгайлж буйг харуулсан нь үнэлгээний зөрүүг илэрхийлэв. Эдгээр үр дүн нь хүүхдийн зан үйлийн илрэл гэр бүл, сургууль, нийгмийн орчны харилцан үйлчлэлээс хамаардаг болохыг баталж байна. Боловсролын орчинд хүүхдийн зан үйлийг илүү бодитой үнэлэх, эцэг эх багшийн хамтын ажиллагааг сайжруулах, зан үйлийн асуудлыг эрт шатанд илрүүлэн урьдчилан сэргийлэх боломж байгааг уг судалгаа харууллаа.

Түлхүүр үг

зургаан настай хүүхэд, зан үйл, зан үйлийн үнэлгээ, боловсролын орчин, эцэг эх багшийн хамтын ажиллагаа, хөгжил, нийгмийн харилцаа, ажиглалт

Удиртгал

Орчин үед хүүхдийн зан үйлийн төлөвшил нь тэдний цаашдын сурлага, нийгмийн харилцаа, хувь хүний хөгжилд чухал үүрэгтэй болохыг олон судлаачид онцлон

тэмдэглэж байна.(Bandura, A., 1977) Хөгжлийн эрт үеийн зан үйлийг судалж, үнэлэх нь хүүхдийн онцлогийг танин мэдэх, тэдэнд зориулсан боловсролын хөтөлбөр болон сэтгэлзүйн дэмжлэгийг үр дүнтэй боловсруулах үндэс болдог. Ялангуяа 6 нас бол сургуулийн өмнөх наснаас сургуулийн насанд шилжих шилжилтийн чухал үе бөгөөд энэ үед хүүхдийн зан үйлд огцом өөрчлөлт, шинэ төлөвшил ажиглагддаг. Тиймээс энэхүү насны хүүхдүүдийн зан үйлийг судлах нь сургуульд бэлтгэх, тэдний орчинд дасан зохицох чадварыг дэмжих, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Орчин үеийн боловсролын салбарт хүүхдийн зан үйлийн төлөвшил нь зөвхөн хувь хүний хөгжилд бус, сургалтын чанар, хамт олны уур амьсгал, багш, эцэг эхийн харилцаа зэрэг олон талт хүчин зүйлтэй нягт уялдаатай чухал үзүүлэлт болж байна.

Зургаан настай хүүхэд нь бага боловсролын түвшинд анхлан хөл тавьж, шинэ орчин, дэг журам, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож эхэлдэг. Энэ үе нь сэтгэлзүй, зан төлөв, өөрийгөө илэрхийлэх чадвар, нийгэмшлийн суурь тавигддаг шийдвэрлэх үе шат юм. Монгол Улсын боловсролын бодлогын баримт бичгүүд, тухайлбал “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр” (2023) болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2021–2025) зэрэгт хүүхдийн сэтгэлзүй, зан үйлийг эрт үеэс үнэлэх, хувь хүний хөгжилд чиглэсэн дэмжлэгийг төр, сургууль, гэр бүлийн хамтын ажиллагаагаар хангах талаар онцгойлон тусгасан байдаг. Гэвч практикт энэхүү бодлогын хэрэгжилт хангалтгүй, боловсролын байгууллагад зан үйлийг системтэй үнэлэх арга зүй, хэрэгсэл дутмаг хэвээр байна. Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн Сан (*UNICEF*) болон UNESCO-гийн олон улсын судалгаагаар(*United Nations Educational, Scientific and Cultural Organisation (UNESCO)*, n.d.) хүүхдийн зан үйлийн асуудлыг эрт шатанд үнэлэх нь:

- Сургуулийн бүтээмж, орчны аюулгүй байдалд нөлөөлдөг
- Сэтгэл заслын үйлчилгээ, багшийн арга барилд чиглэл өгдөг;
- Эрдэлт нөхцөлд байгаа хүүхдэд тусламж үзүүлэх чухал суурь болдог гэж үздэг.

Иймд энэхүү судалгаа нь боловсролын чанар, хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, багшийн мэргэжлийн ур чадвар, сэтгэлзүйн дэмжлэг зэрэг олон асуудалтай уялдах онол ба практикийн ач холбогдол бүхий судалгаа юм.

Онолын үндэс

Бихевиоризмын онол нь «behavior» буюу «зан үйл» гэсэн англи үгнээс гаралтай. (Skinner, n.d.) Энэхүү чиглэлийн гол төлөөлөгчид болох Б.Ф. Скиннер, Э.Торндайк, Ж.Уотсон, И.П. Павлов нар зан төлөвийн төлөвшил нь орчны нөлөөнд бүрэн хамааралтай гэж үзжээ.

Бихевиоризмын онолын гол санаа нь:

- Суралцах үйл явц нь өдөөлт-хариу үйлдлийн холбоонд суурилдаг.
- Зан үйлийг хэлбэржүүлэхэд урамшуулал ба шийтгэл чухал үүрэгтэй.
- Дотоод сэтгэлгээ, мэдрэмжийг бус, зөвхөн ажиглагдах үйлдлийг судлах ёстой.

Скиннерийн “үйлдлийн нөхцөл байдал” (operant conditioning) нь зан үйлийг бэхжүүлэх, эсвэл сулруулахад урамшуулал ба шийтгэл хэрхэн нөлөөлдөгийг харуулсан бол Павловын “сонгодог нөхцөл” (classical conditioning) нь байгалийн өдөөлтийг төвийг сахисан өдөөлттэй хослуулснаар шинэ зан үйл үүсэхийг тайлбарласан байдаг. Эдгээр үзэл санаа нь хүүхдийн зан үйлийг ажиглаж, бэхжүүлэх аргаар хөгжүүлэх сургалтын үндэс болж, өнөөдрийн боловсролын орчинд ч өргөн хэрэглэгдэж байна. Мөн А.Бандура нь нийгмийн суралцах онолын хүрээнд хүүхдийн зан үйл нь орчны загварчлал, ажиглалт, дуурайлалд үндэслэн хөгждөг болохыг тайлбарласан. Хүүхэд урамшуулал, шийтгэлийн нөлөөгөөр зан үйлийн илрэл нь төлөвшдөг бөгөөд мөн жирийн ажиглалт, дуурайлтаар бусдаас суралцдаг гэж тайлбарладаг. Зан үйл гэдэг нь хүний дотоод сэтгэлгээ, мэдрэмж, үнэлэмж, итгэл үнэмшил, зан чанар зэрэг сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөөгөөр илэрдэг гадаад илрэлийн нийлбэр юм.

Судалгааны хэрэглээ: Зан үйлийг үнэлэх ба хөгжүүлэх практик

Сүүлийн жилүүдэд МУБИС, Боловсролын хүрээлэн, Хүүхдийн төлөө үндэсний газар зэрэг байгууллагууд хамтран, хүүхдийн хөгжил, зан үйлийн зорилтот үнэлгээ, сургалтын орчинд илрэх зан төлөвийн ялгаа, багш, эцэг эхийн үнэлгээний харьцуулалт зэрэг асуудлуудыг судалсан байна. Эдгээр судалгаанд хүүхдийн зорилтот зан төлөвийн үнэлгээ, сургалтын орчин дахь зан үйлийн илрэл, эцэг эх ба багшийн үнэлгээний ялгаа зэрэг асуудлыг хамруулсан нь зан үйлийг шинжлэх ухааны үндэстэй үнэлэх суурийг тавьсан юм. Канадын Монреалийн их сургуулийн сэтгэл судлалын профессор Ричард Э.Тремблей (Richard E. Tremblay) удирдсан бөгөөд хүүхдийн түрэмгий зан авир нь насанд хүрсэн насанд гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг урьдчилан таамаглах чухал хүчин зүйл болохыг тогтоосон байна. (Pingault et al., 2013) Эдгээр судалгаанууд зан үйлийг зөв үнэлж, хөгжүүлэх нь эрт үеийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ, багшийн сэтгэлзүйн дэмжлэг, сургалтын орчны уур амьсгал зэргийг сайжруулах чухал хүчин зүйл болохыг харуулж байна. Хамаарал ба харьцуулалт: Бихевиоризм ба Нийгмийн суралцах онол А.Бандурагийн нийгмийн суралцах онол нь бихевиоризмыг өргөжүүлж, хүүхдийн зан үйл зөвхөн өдөөлт-хариу үйлдлээр бус, ажиглалт, дуурайл, загварчлалын замаар төлөвшдөг гэж тайлбарладаг.

Хүснэгт 1. Бихевиоризм ба Нийгмийн суралцахуйн онолын харьцуулалт

Үзүүлэлт	Бихевиоризм (Skinner, Watson, Thorndike)	Нийгмийн суралцахуйн онол (Bandura)
Суралцах үндэс	Өдөөлт- хариу үйлдэл (Урамшуулал ба шийтгэл)	Ажиглалт, дуурайл, загварчлал
Дотоод хүчин зүйл	Үл тоомсорлодог	Хүлээлт, итгэл, сэтгэлгээ оролцдог
Гол ойлголт	Оперант ба сонгодог нөхцөл	Modeling (загварчлал), Self-efficacy
Хүүхдийн зан үйл	Гадаад орчны өдөөлтөд хариу үйлдэл	Орчны нөлөө, ажиглалт, суралцахуйн нэгдэл

Бандурагийн онолоор хүүхэд бусдын зан үйлийг ажиглаж, өөрийн зан төлөвт дуурайж хэвшүүлдэг бөгөөд урамшуулал, шийтгэлийн талаар хүсэн хүлээж буй үр дүнгийн итгэлцэлээр дамжуулан зан төлөвийг зохицуулдаг гэж үздэг. Ингэснээр бихевиоризм ба нийгмийн суралцах онол хоёр нь хоорондоо ялгаатай атлаа зан үйлийн төлөвшлийг орчны нөлөө, суралцах туршлагатай холбон тайлбарладаг нийтлэг суурьтай юм.

Бихевиоризмын болон нийгмийн суралцах онолууд нь хүүхдийн зан үйлийн төлөвшлийг тайлбарлахад чухал онолын үндэс болдог. Эдгээр онолын уялдаа нь хүүхдийн зан төлөвийг зөв чиглүүлэхэд урамшуулал, ажиглалт, дуурайл, орчны дэмжлэг зэрэг хүчин зүйлсийг оновчтой ашиглах шаардлагатайг харуулж байна. Монголын боловсролын бодлогын баримт бичгүүдтэй холбон үзэхэд, зан үйлийн үнэлгээ болон хөгжүүлэлтийг системтэй хэрэгжүүлэх нь сургалтын чанарыг дээшлүүлэх, сэтгэлзүйн дэмжлэгийг сайжруулах, хүүхдийн нийгмийн дасан зохицол, аюулгүй байдлыг хангах гол нөхцөл болж байна.

Судалгааны зорилго: Зургаан настай хүүхдийн зан үйлийн онцлогийг илрүүлэх, эцэг эх ба багшийн үнэлгээг харьцуулан задлан шинжлэх

Судалгааны зорилт

- Хүүхдийн зан үйлийг үнэлэх
- Эцэг эх ба багшийн үнэлгээг харьцуулан судлах
- Багш, эцэг эхэд зориулсан зөвлөмж боловсруулах

Судалгааны асуудал: Монгол Улсад бага боловсролын агуулга, арга зүй шинэчлэгдэж байгаа өнөө үед хүүхдийн зан үйлийг системтэй үнэлэх, сургуулийн орчинд зан төлөвийн асуудлыг эрт илрүүлэх нь боловсролын чанар, хүүхдийн нийгмийн дасан зохицолд чухал ач холбогдолтой асуудал юм. Гэвч одоогийн практикт хүүхдийн зан үйлийг нэг талаас гол төлөв эцэг эхийн үнэлгээнд тулгуурлан тодорхойлдог нь мэдээллийн бодит байдал, цогц үнэлгээний нарийвчлалд хязгаар үүсгэж байна. Иймд хүүхдийн зан үйлийг эцэг эх ба багшийн хамтарсан үнэлгээгээр судалж, хоёр талын дүгнэлтийн ижил ба зөрүүтэй талыг тодруулах шаардлага бий болж байна. Судлагдахуун: Зургаан настай хүүхдийн зан үйл (сургуулийн орчин, гэр бүлийн орчин дахь зан төлөвийн илрэл)

Судлах зүйл: Эцэг эх ба багшийн үнэлгээнд илэрч буй зан үйлийн онцлог, зөрүү ба уялдаа

Судалгааны таамаглал: Зургаан настай хүүхдийн зан үйлийг үнэлэхдээ зөвхөн эцэг эхийн асуумжид тулгуурлах нь тодорхой нэг өнцгөөс хязгаарлагдсан мэдээлэл өгдөг бол, эцэг эхийн асуумжийг багшийн ажиглалттай хослуулсан системтэй үнэлгээний арга зүй нь илүү цогц, нарийвчилсан, бодитой үр дүн гаргах боломжтой.

Судалгааны хамрах хүрээ, арга аргачлал

Энэхүү судалгааны ажил нь Дархан хотын “Од” ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид суралцаж буй зургаан настай хүүхдүүдийг төлөөлөн 51 эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багшийг хамруулсан юм. Судалгааны зорилго нь хүүхдийн зан үйлийн онцлогийг Айбергийн зан үйлийн асуулга болон ажиглалтын аргаар тодорхойлох явдал байв.

Судалгааны аргууд: Энэхүү судалгаанд дараах онолын болон эмпирик аргуудыг ашиглана.

1. Айбергийн зан үйлийн асуулга (Eyberg Child Behavior Inventory – ECBI): Энэхүү арга нь эцэг эхийн мэдээлэлд тулгуурлан хүүхдийн зан үйлийг үнэлдэг олон улсын түвшинд найдвартай, хүчин төгөлдөр байдлыг баталсан хэрэгсэл юм (Eyberg et al., 1994; Туяа Б., 2012). Асуулгын нийт 36 зүйлээс бүрдсэн Intensity Scale-ийн онооны хязгаар 36–252 ба нийт 131 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд хүүхдийг “зан үйлийн тулгамдсан асуудалтай (Clinical range)”, 130 болон түүнээс доош бол “хэвийн (Normal range)” гэж ангилдаг. Айбергийн асуулга нь эцэг эхчүүдээс хүүхдийн сүүлийн үеийн зан үйлийн талаар голчлон мэдээлэл цуглуулдаг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, найдвартай болон хүчин төгөлдөр байдлыг тогтоогдсон аргачлал юм. (Туяа Б., 2012) Бид энэхүү судалгаандаа эцэг эхэд зориулсан хувилбарыг ашиглах болно. Учир нь эцэг эхчүүд хүүхдийнхээ өдөр тутмын зан үйлийг хамгийн сайн ажигладаг хүмүүс гэж үздэг. Хүүхдийн зан үйлийг үнэлэх Айберг-ийн асуулгыг Шейла Айберг зохиосон байна. Гол зориулалт нь хүүхдийн зан үйлийн асуудал бэрхшээлийг үнэлэх, зориулалттай. Тайлбар: ECBI-нь хүүхэд болон өсвөр насныхны зан үйлийн бэрхшээлийг үнэлэх 36 даалгавар бүхий зэмсэг юм. Энэ нь эцэг эхэд зориулсан ихэд өргөн хэрэглэгддэг үнэлгээний хэмжүүрийн нэг. ECBI-нь бусад түрэмгий хандах хандлага, дуулгаваргүй байдал, гэнэтийн уур уцаар, эвдэн сүйтгэх, бусдын дургүйцлийг хүргэх зан үйл, хулгай хийх, худал хэлэх зэрэг зан үйлийн өргөн хүрээг үнэлдэг. ECBI-нь 2-17 насны хүүхдийг үнэлэх эцэг эхэд зориулагдсан аргачлал юм. Энэхүү аргачлал нь хэвийн дунд гарсан ахиц өөрчлөлтийг үнэлэх зориулалттай.

2. Ажиглалтын арга: Хүүхдийн зан үйлийн бодит илрэл, харилцаа, сэтгэл хөдлөл, даалгаварт хандах байдал зэргийг анги танхимын орчинд 3 долоо хоногийн турш ажиглан, тэмдэглэл хөтлөх. Ажиглалтын шалгуурт дараах үзүүлэлтүүд орсон.

1. Заавар, дүрэмд үл захирагдах
2. Түрэмгий авир (түлхэх, цохих, доромжлох)
3. Хэт сатаарах, төвлөрөлгүй байх
4. Сурах хүсэлгүй байх
5. Тоглоом болон бусад зүйлсийг эвдэх
6. Бусадтай харилцахад хэцүү байх Тэмдэглэгээний тайлбар: Давтамж: 1 = Маш ховор (0-1 удаа), 2 = Ховор (2-3 удаа), 3 = Заримдаа (4-5 удаа), 4 = Олон удаа (6-8 удаа), 5 = Маш олон удаа (9 дээш) Ажиглагдсан эсэх: ✓ Ажиглагдсан, Ч Ажиглагдаагүй Асуудал уу? Т = Тийм, Ү = Үгүй

3. Судалгааны дотоод хүчин зүйлсийг хяналтын хувьд: ажиглагчид ижил шалгуур, зааврыг мөрдөх, ажиглалтын хугацаа тогтмол байлгах. Гадаад хүчин зүйлсийг хянахын тулд анги доторх орчныг тогтмол, саадгүй байлгаж, бусад оролцогчдын оролцоо, анхаарал сарниулах зүйлсийг багасгах.

Судалгааны үр дүн

Бидний судалгаанд 51 эцэг эх, асран хамгаалагч оролцов. Үүнд: эх (78.4%, n=40), эцэг (9.8%, n=5), асран хамгаалагч (11.8%, n=6) хамрагдсан байна.

График 1. Хүүхэд бүрийн асуумжийн давтамж

Айберг-ийн 36 асуулгын давтамжийн график



Графикийн статистик дүн шинжилгээгээр зан үйлийн зарим асуултууд өндөр давтамжтай илэрчээ. Бандурагийн «Нийгмийн суралцах онол» (Social Learning Theory)-оор тайлбарлахад, өндөр давтамжтай зан үйл (жишээ: №4, №12) нь ихэвчлэн гэр орчин болон цэцэрлэгт даган дуурайх замаар суралцсан зан үйл байж болзошгүй. Эцэг эхийн зан төрх, багшийн загвар үзүүлэлт нь хүүхдийн зан үйлд шууд нөлөөлдөг (Bandura, 1977). Ихэнх хүүхдүүдийн зан үйлийн үнэлгээний оноо 3–4 онооны хооронд (75) тархсан нь ердийн хөгжлийн хэв шинжтэй нийцэж байна.

Хүснэгт 2. Зан үйлийн ангиллын статистик үзүүлэлт

Ангилал	Оноо	Тоо (n)	Хувь (%)	95% CI
Хэвийн (Normal)	<131	48	94.10%	87.2–98.1%
Тулгамдсан асуудалтай (Clinical)	≥131	3	5.90%	1.9–12.8%
Нийт	-	51	100%	-

Дундаж оноо: $M = 78.4$ ($SD = 32.6$, $Range = 32-163$) Хүүхдүүдийн онооны тархалт нормаль тархалтаас статистикийн хувьд ихээхэн зөрсөн (Shapiro-Wilk test: $W = 0.89$, $p < 0.05$) нь зарим хүүхдүүд онцгой өндөр оноо авснаас үүдэлтэй. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын дийлэнх нь хэвийн (Normal, <131 оноо) ангилалд багтаж, 48 хүүхэд буюу 94.1% байна. Харин зан үйлийн тулгамдсан асуудалтай (Clinical, ≥131 оноо) 3 хүүхэд буюу 5.9% байгаа нь дээрх үзүүлэлтээс ажиглагдлаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд 22, 35, 39 кодтой хүүхэд бусдаасаа харьцангуй өндөр оноо авсан нь тэдний зан үйл бусдаас илүү идэвхтэй (hyperactive) эсвэл сэтгэл мэдрэмж өндөр (highly sensitive) байж болзошгүй бөгөөд зарим тохиолдолд нэмэлт анхаарал шаардлагатай байж болно.

Хүснэгт 3. Эцэг эх ба багшийн үнэлгээний харьцуулалт

Судалгаанд оролцогч	Дундаж(M)	Стандарт хазайлт (SD)	n
Эцэг эх	82.3	34.2	51
Багш	74.6	28.9	51
Зөрүү	7.7	-	-

Paired t-test-ийн дүнгээр эцэг эх багшаас статистикийн хувьд мэдэгдэхүйц өндөр үнэлгээ өгсөн:

$t(50) = 2.34$, $p = 0.023$, Cohen's $d = 0.25$ (жижиг хэмжээний эффект). Энэ нь эцэг эх өөрийн хүүхдийн зан үйлийн асуудлыг багшаас илүү үнэлэх хандлагатай байгааг харуулж байна

Эцэг эхийн үнэлгээ өндөр байх шалтгаан:

- Хүүхэдтэй илүү их цаг өнгөрөөх
- Сэтгэл санааны хамаарал өндөр
- Гэрийн орчинд илүү чөлөөтэй зан үйл их илрэх магадлалтай.

Багшийн үнэлгээ бага байх шалтгаан:

- Олон хүүхэдтэй харьцуулах боломж (relative comparison)
- Хичээлийн цагт зан үйл илүү хяналттай байх
- Мэргэжлийн өнцгөөс илүү объектив үзэх

График 2. Зан үйлийн давтамжийн дундаж үзүүлэлт




Сурагчдын зан үйлийн дундаж онооны шинжилгээний үр дүнгээс харахад хамгийн өндөр оноо буюу 4.74-ийг “үйлдэлдээ хариуцлага хүлээхээс татгалзах” үзүүлэлт эзэлж байгаа нь хүүхдүүд өөрийн үйлдэл, үүрэг, алдаандаа хариуцлагагүй хандах, бусдад тохих хандлага давамгайл байгааг илтгэнэ. Энэхүү зан үйл нь бусад сөрөг зан

авирын үндэс болж, сурах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болохыг харуулж байна. Мөн “хичээлдээ анхаарал төвлөрүүлэхгүй байх” (4.56) нь сурагчдын сурлагын амжилтад саад болж буй гол хүчин зүйл бөгөөд энэ нь суралцах сонирхол сулрах, хичээлээ дутуу хийх зэрэг бусад үзүүлэлттэй нягт холбоотой байна. Мөн “биеэ барьж чадахгүй байх” (4.52) болон “түргэн уурлах” (4.18), “энгийн зүйлд сэтгэлээр унах” (4.08) зэрэг нь өөрийгөө удирдах чадвар хангалтгүй, хяналт, сэтгэл зүйн тэсвэр хатуужил сул, өөртөө итгэлгүй байдал ажиглагдаж буйг харуулж байна. Эдгээр нь хамт олонтой харилцах харилцаанд зөрчил үүсгэх, хичээлд оролцох идэвхийг бууруулах шалтгаан болж байгаа нь тодорхой байна. Мөн багшаас сургууль дээрх зан үйлийг ажиглалтын аргаар судалгаа авч үр дүнг тооцож үзэв. Бид ажиглалтын хүснэгтээ зохиомжлон боловсруулж 7 хоног ажиглалт хийж тэмдэглэл хөтөлсөн бөгөөд ажиглалт нь зургаан үндсэн үзүүлэлтийн дагуу явагдсан. (Хавсралт 1-ээс үзнэ үү). Энэхүү үзүүлэлтүүдийг сонгохдоо нэгдүгээр судалгааны үр дүнд ажиглагдсан өндөр үзүүлэлтүүдийг сонгож аван анги нийтээр ажиглаж тэмдэглэл хийв. Тэмдэглэл хийхдээ дараах хэлбэрийг ашиглав. Үүнд:

- Ажиглагдсан эсэх: ✓ Ажиглагдсан, Ч Ажиглагдаагүй
- Энэ нь асуудал уу? Т = Тийм, Ү = Үгүй

График 2. Зан үйлийн илрэл илүү тод ажиглагдсан сурагчдын үзүүлэлт (7 хогийн давтамж)



Судалгаанд оролцсон ихэнх сурагчид зан үйлийн түрэмгий шинж, анхаарал сул байх зэрэг зан үйл нь илүү тод ажиглагдсан. Жишээ нь, А.17, А.22, А.30 кодтой сурагчдад энэ шинж тэмдэг илүү өндөр байна. Эдгээр хүүхдүүдэд тусгай дэмжлэг, багшийн анхаарал шаардлагатай бөгөөд мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах хэрэгцээ байгааг илтгэж байна. Багшийн ажиглалт, эцэг эхийн асуумжийн үр дүн хоорондоо нягт уялдаатай байгаа нь нь дээрх судалгаануудын үр дүнгээс тодорхой ажиглагдаж байна. Ажиглалтаар тодорхойлогдсон зан үйлүүд нь суралцах орчны зохион байгуулалт, багшийн удирдлага, хамт олны харилцаа зэрэг хүчин зүйлсээс хамаарч өөрчлөгдөж болох юм.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан 51 хүүхдийн 94.1% (n=48) нь хэвийн (оноо <131), харин 5.9% (n=3) нь зан үйлийн тулгамдсан асуудалтай (оноо ≥131) байгаа нь тодорхойлогдлоо. Дэлхийн дундаж (3-7%, WHO, 2022) үзүүлэлттэй тохирч байна.
2. Зан үйлийн давтамжийн шинжилгээгээр өндөр давтамжтай асуултууд (№1, 4, 9, 12, 36: M=4.1-4.5) нь ихэвчлэн идэвхтэй зан, анхаарал сарниулах шинж чанартай холбоотой бол, бага давтамжтай асуултууд (№10, 19, 23, 26, 33, 34: M=1.4-1.9) нь сэтгэл гутрал, нийгэмд дасан зохицох асуудалтай холбоотой байна.
3. Эцэг эх болон багшийн үнэлгээний хооронд статистикийн хувьд мэдэгдэхүйц зөрүү ($\Delta=7.7$ оноо, $t(50)=2.34$, $p=0.023$) илэрсэн нь олон талт үнэлгээ хийх шаардлагатайг харуулж байна. Бандурагийн нийгмийн суралцах онол (1977) болон Bronfenbrenner-ийн экологийн систем онолоор тайлбарлахад, хүүхэд янз бүрийн орчинд өөр өөр зан үйл үзүүлдэг тул эцэг эх, багшийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой байна.
4. Өндөр оноо авсан 3 хүүхдэд (№22, №35, №39) сэтгэл зүйн цогц үнэлгээ хийх шаардлагатай.
5. Эцэг эх, багшийн харилцан ойлголцлыг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах
6. Зан үйлийн асуудлыг эрт илрүүлэх сэргийлэх хөтөлбөр боловсруулах
Энэхүү судалгаа нь Монгол орны бага боловсролын сургалтын орчинд хүүхдийн зан үйл, сэтгэл зүйн дэмжлэг, багшийн удирдлага, эцэг эхийн оролцоог сайжруулахад практик ач холбогдолтой бөгөөд боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийг сайжруулах үндэслэл болно.

Зөвлөмж

- I. Боловсролын байгууллагын түвшинд: Сургуулиудад сэтгэл зүйн үйлчилгээний системийг бүрдүүлж, улирал бүр зан үйлийн үнэлгээ хийх шаардлагатай. Багш нарыг зан үйлийн менежмент болон эерэг зан үйлд суурилсан дэмжлэгийн арга зүйд сургах, мэргэшүүлэх нь чухал. Тулгамдсан асуудалтай 3 хүүхдэд (5.9%) цогц сэтгэл зүйн үнэлгээ хийж, хувь хүний дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
 - II. Гэр бүлийн орчинд: Эцэг эхэд хүүхдийн хөгжил төлөвшлийн талаар сургалт зохион байгуулж, хүүхдийн зан үйлд нөлөөлөх эерэг арга барилд суралцуулах шаардлагатай. Эцэг эх, багшийн тогтмол хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зүйтэй.
 - III. Бодлогын түвшинд: Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх. Эрсдэлтэй хүүхдийг эрт илрүүлэх боломжийг бий болгох. Сургуулиудад сэтгэлзүйчийн байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, зан үйлийн асуудлын илрэлийг 5.9%-иас 3.5% хүртэл бууруулах зорилт тавих нь зүйтэй.
- Эдгээр зөвлөмж нь Бандурагийн нийгмийн суралцах онол болон олон улсын жишиг туршлагад тулгуурлан, эцэг эх-багш-сэтгэл зүйчийн гурвалсан хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдсэн болно.

Талархал

Энэхүү судалгаанд хамрагдсан Дархан хотын ерөнхий боловсролын сургуулийн I ангийн 51 эцэг эх, асран хамгаалагчид болон судалгааг удирдан чиглүүлсэн МУБИС-ийн Багшийн сургуулийн магистр хамгаалуулах зөвлөлийн гишүүд болон сэтгэл судлалын багш, доктор Г.Бямбаатогтоход чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ном зүй

1. Bandura, A. (1977). Self-efficacy: The exercise of control.
2. Pingault, J.-B., Сфтй, S. M., Lacourse, E., Galйra, C., Vitaro, F., & Tremblay, R. E. (2013). Childhood Hyperactivity, Physical Aggression and Criminality: A 19-Year Prospective Population-Based Study. PLoS ONE, 8(5), e62594. <https://doi.org/10.1371/journal.pone.0062594>
3. Skinner, B. F. (n.d.). Science and human behavior.
4. United Nations Educational, Scientific and Cultural Organisation (UNESCO). (n.d.).
5. Туяа Б. (2012). Клиник практикт хэрэглэх аргачлал.

Хавсралт

Хавсралт 1. Ажиглалтын хуудас (Observation Sheet Template)

Сурагчийн код	Ажиглалтын давтамж	Үл захирагдах	Түрэмгий авир	Анхаарал сул	Сурах хүсэлгүй	Тоглоом эвдлэх	Бусадтай харилцах	Тайлбар
A.01								
A.02								
A.03								
A.04								
...								
A.52								

Энэхүү хуудас нь ажиглалтын загвар бөгөөд судалгааны явцад бөглөхөд ашиглана. Тэмдэглэл хөтлөхгүйгээр зөвхөн бүх шалгуур үзүүлэлтүүдийг оноогоор тэмдэглэх боломжтой.

STUDY ON THE BEHAVIOR OF YOUNG SCHOOL-AGED CHILDREN (A Case Study of Six-Year-Olds)

^aByambatogtokh G., ^bErdenezul E.

^aTeachers School, MNUE;

^bTeachers School, MNUE

Corresponding author: Byambatogtokh@msue.edu.mn 

Abstract

The present study aimed to examine the behavioral characteristics of six-year-old children and to compare parental and teacher assessments. The study sample consisted of 60 first-grade students from “Od” General Education School in Darkhan City. Data were collected through a combination of questionnaires and structured observations. Analysis of the results revealed that 65% of children predominantly exhibited positive behaviors, including polite social interactions (42%), adherence to rules (37%), and helpfulness toward others (31%), whereas 35% displayed predominantly negative behaviors, such as poor attention and concentration (22%), rule-breaking (18%), aggressive tendencies (12%), and hyperactivity (9%). Parental evaluations indicated that 72% of children were primarily characterized by positive behaviors, while teacher assessments reported only 58% as positive and 42% as predominantly negative, highlighting discrepancies between home and school observations. These findings underscore the influence of family, school, and social environment interactions on children’s behavioral manifestations. Furthermore, the results emphasize the importance of accurate behavioral assessment in educational settings, fostering effective collaboration between parents and teachers, and the early identification and prevention of behavioral issues.

Keywords

six-year-old children, behavior, behavioral assessment, educational environment, parent-teacher collaboration, development, social interaction, observation
